

БАТЛАВ
АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА



/С.ЭНХБААТАР/

БАТЛАВ
ХУЛАН ШОУ ЭНТЕРТАЙНМЕНТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Б.Золбадрах
ХХК

/Б.ЗОЛЗАЯА/

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2021 оны 07-р сарын 21-ний өдөр

№ ХА/А-2021/05

Улаанбаатар хот

Энэхүү “Хамтран ажиллах гэрээ” (цаашид “Гэрээ” гэх)-г Монгол Улсын Иргэний хуулийн 476-480 дугаар зүйлийг үндэслэн,

Нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 21-р хороо Архивын ерөнхий газар түүнийг төлөөлж Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Х.Цогтбаатар /цаашид “Захиалагч” гэх/

Нэгөө талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, Төмөрчний гудамж Арга билэг төвийн 405 тоот хаягт орших “Хулан шоу энтеертайнмент” ХХК, түүнийг төлөөлж менежер Б.Золбадрах нар /цаашид “Гүйцэтгэгч”, хамтад нь “Талууд” гэх/ харилцан тохиролцож, байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү гэрээгээр студи нь захиалагчийн телевизийн шторк (цаашид “Захиалгат ажил” гэх)-ийг сүүлийн үеийн техник, технологийг ашиглан Full HD форматаар мэргэжлийн түвшинд дуу, дурсний өндөр чанартай хийж, хүлээлгэн өгөх, захиалагч нь захиалгат ажлын төлбөрийг студид төлөхтэй холбогдон талуудын хоорондын харилцааг зохицуулахад оршино.

1.2 Захиалгат ажил нь захиалагчийн баталсан үндсэн санаа, үйл ажиллагааны агуулгыг бүрэн тусгасан бүтээл байна.

1.3 Энэхүү гэрээгээр захиалгат ажлыг хийж гүйцэтгэх болон түүнийг өмчлөхтэй холбоотой талуудын эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр тусгасан болно.

Хоёр. Гэрээний хугацаа

2.1 Захиалгат ажил гүйцэтгэх ерөнхий хугацаа 7 хоног байна. Үүнд:

2.1.1 Эхлэх өдөр: 2021 оны 07-р сарын 21-ны өдөр,

2.1.2 Дуусах өдөр: 2021 оны 07-р сарын 28-ны өдөр хүртэл байна.

2.2 Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулснаас хойш гэрээний хугацаа дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

2.3 Захиалагч захиалга өгснөөс хойш 1 (нэг) хоногийн дотор студи нь урьдчилсан байдлаар захиалгат ажлын зохиолыг биечлэн танилцуулж, захиалагчаас саналыг авна.

2.4 Захиалагч захиалгат ажлыг захиалах үед “Захиалгын акт” (Хавсралт-1), захиалгат ажлыг бүрэн хүлээн авсан тохиолдолд “Ажил дүгнэсэн акт” (Хавсралт-2)-ыг тус бүр үйлдэх бөгөөд Талууд гарын үсгээр баталгаажуулна.

2.5 Хавсралт нь энэхүү Гэрээний салшгүй хэсэг байна.

Гурав. Гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл

3.1 Захиалагч нь захиалгат ажлын урьдчилгаа болох 50 /тавь/ хувь буюу 4.000.000₮ /Дөрвөн сая төгрөг/-ийг ажлын 1 хоногийн дотор, үлдэгдэл төлбөр болох 50 /тавь/ хувь буюу 4.000.000₮ /Дөрвөн сая төгрөг/-ийг захиалгат ажил дууссаны дараа ажлын 3 хоногийн дотор Студийн дансанд нэхэмжлэхийн дагуу тус тус шилжүүлнэ.

3.1.1 Банк: **Төрийн банк**.

3.1.2 Төгрөгийн дансны дугаар: **340004005761**. Хуланшоу энтертеймент ХХК

Дөрөв. Банкны эрх, үүрэг

4.1 Захиалагч нь дараах эрх эдэлнэ. Үүнд:

4.1.1 Студиэр захиалгат ажлын зохиолыг бэлдүүлэн түүнтэй танилцах, зохиолын дагуу захиалгат ажлыг чанарын өндөр түвшинд хийлгэж авах;

4.1.2 Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, санал гомдлоо илэрхийлэх, ажил үйлчилгээг өндөр түвшинд, Гэрээний хугацаанд гүйцэтгэхийг шаардах;

4.1.3 Захиалгат ажлын явцтай танилцах, батлагдсан зохиолын дагуу тухайн ажлыг өөрийн санаагаар өөрчлөх, саналаа тусгах;

4.1.4 Гэрээний хугацаанд захиалгат ажил батлагдсан зохиолын дагуу биш, шаардлага хангахгүй, чанар муутай хийж гүйцэтгэсэн тохиолдолд захиалгат ажлыг зохиолын дагуу дахин чанартай хийхийг шаардах, дахин хийлгэх;

4.1.5 Бэлэн болсон захиалгат ажлыг буюу бүтээлийг өмчлөх эрхтэй ба өмчлөгчийн хувьд оюуны бүтээлийн өмчлөгчийн хуульд заасан бүх эрхийг эдлэх;

4.1.6 Тухайн захиалгат ажилд оролцох, тоглох хүнийг сонгоход саналаа өгөх, гол дүрийн жүжигчин, моделийг өөрсдийн саналаар солих;

4.1.7 Тухайн захиалгат ажлыг хэд хэдэн хувилбартайгаар үнэ төлбөргүй богиносгож авах, засвар хийлгэх;

4.1.8 Захиалгат ажлын эх бэлтгэлийн задгай файлыг Студиэс үнэ төлбөргүй авах;

4.1.9 Зураг авалтын үед захиалгат ажилд ашиглах фото зураг үнэ төлбөргүй авхуулах;

4.1.10 Гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг Студиэс шаардах.

4.2 Захиалагч нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

4.2.1 Өөрийн мэдээллийн үнэн зөв, бодит байдлын хариуцлагыг бие даан хариуцах;

4.2.2 Гүйцэтгэж буй захиалгат ажлын зохиолыг батлах, захиалгат ажилтай холбоотой мэдээллээр Студийг хангах;

4.2.3 Гэрээний дагуу захиалгат ажлын хөлсийг Гэрээнд заасан хугацаанд нь төлөх;

4.2.4 Олны танил, нэр хүндтэй хүмүүсийг рекламд тоглуулах, гадаадад болон хотоос гадна зураг авахтай холбоотой зардлыг Захиалагч нэмж хариуцах.

Тав. Студийн эрх, үүрэг

5.1 Студи нь дараах эрх эдэлнэ. Үүнд:

5.1.1 Захиалагчаас гэрээнд заасан санхүүжилтийг нэхэмжлэх;

5.1.2 Гүйцэтгэж буй ажилтай холбоотой шаардлагатай мэдээллийг Захиалагчаас шаардах;

5.1.3 Захиалгат ажлын гол дүрийн жүжигчнийг Захиалагчид санал болгох, санал бодлоо солилцох;

5.1.4 Захиалагчаас Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах.

5.2 Студи нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

5.2.1 Гэрээнд заасан ажил, үйлчилгээг чанарын өндөр түвшинд, тогтоосон хугацаанд гүйцэтгэж, Захиалгат ажлыг өмчлөх зохиогчийн эрхийн хамт хүлээлгэн өгөх;

5.2.2 Захиалсан ажлын утга санаа алдагдсан, батлагдсан эх зохиолоос гажуудуулсан, чанарын шаардлага хангахгүйгээр гүйцэтгэсэн тохиолдолд уг ажлыг Студи нь өөрийн зардлаар дахин хийж гүйцэтгэх;

5.2.3 Захиалагчийн хүсэлтээр тухайн захиалгат ажлын засварыг үнэ төлбөргүй бэлтгэн өгөх;

5.2.4 Өөрийн студиэс захиалгат ажилд оролцох жүжигчид болон тэдгээрийн хувцаслалт, зураг авах объект зэргийг Захиалагчид урьдчилан мэдээлж, саналыг тусгах;

5.2.5 Захиалгат ажилд тоглох жүжигчдийг олох, проб үзүүлэх (хувцас, нүүр будалт, үс засалтыг бэлтгэх), техникийн ажилтан болон техник тоног төхөөрөмжийг Гэрээний бүхий л хугацаанд бэлэн байлгах;

5.2.6 Гүйцэтгэж буй ажлын явц, түүнтэй холбоотой саналыг Захиалагчтай солилцож, Захиалагчийн саналыг тусгах;

5.2.7 Зураг авалтын үед захиалгат ажилд ашиглах фото зургийг авч, Захиалагчид хүлээлгэн өгөх;

5.2.8 Захиалагчийн захиалгат ажил сурталчилгаанд ашигласан видео дурс, файл, аялгуу зэргийг өөр газрын захиалгат ажил дээр ашиглахгүй байх;

5.2.9 Захиалгат ажлын богиносогон хувилбар, засварыг тус тус бэлтгэн үнэ төлбөргүй Захиалагчид хүлээлгэн өгөх.

Зургаа. Хариуцлага

6.1 Студи Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, тохиролцсон хугацаанд захиалгат ажил бэлэн болоогүй болон батлагдсан зохиолын дагуу биш, шаардлага хангаагүй, чанар муутай хийж гүйцэтгэсэн бөгөөд түүнийг засаж, сайжруулах боломжгүй тохиолдолд Захиалагчийн санаачилгаар Гэрээг цуцалж, төлбөрийг буцаан авна.

6.2 Студи нь Гэрээний үүргийг биелүүлээгүй буюу Захиалагчийн ажлыг цаг хугацаандаа дуусган хүлээлгэн өгч чадаагүй тохиолдолд хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувиар алданги тооцож төлнө.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

7.1 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нэхцэл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлуулах, эсвэл Талууд төлбөрийг харилцан тохиролцож болно.

7.2 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн, эсэргүүцлийн хөдөлгөөн, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.

Найм. Нууцлал

8.1 Талууд гэрээний нууцлалыг чанд сахиж, гэрээний нэхцэл журмыг гадагш задруулахгүй байх үүрэгтэй. Задруулсан тохиолдолд буруутай тал нөгөө талдаа учирсан хохирлыг бүрэн хариуцна.

8.2 Талууд гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдох харилцан солилцсон мэдээлэл, баримтын нууцлалыг гэрээ байгуулагдсанаас хамгийн багадаа 3 сарын хугацаагаар хадгалах бөгөөд нөгөө Тал зөвшөөрөл олгосон эсвэл хууль тогтоомжоор шаардсанаас бусад тохиолдолд аливаа гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй байх, Гэрээнд заагдаагүй зорилгоор ашиглахгүй байхаар тохиролцов.

Ес. Маргаан шийдвэрлэх

9.1 Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг Талууд зөвшилцлийн замаар шийдвэрлэх бөгөөд хэрэв зөвшилцэлд эс хүрвэл Монгол Улсын шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

Арав. Бусад

10.1 Гэрээг Монгол хэл дээр бичгээр 2 хувь үйлдэж, тал тус бүр 1 хувийг хадгалах ба хувь тус бүр хууль, эрх зүйн хувьд нэгэн адил хүчинтэй байна.

10.2 Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ аль нэг талынхаа албан ёсны зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд хэсэгчилсэн буюу бүрэн хэмжээгээр шилжүүлэх эрхгүй.

10.3 Захиалагчийн нэр өөрчлөгдөх, банкны бүтэц, удирдлага өөрчлөгдөх нь Гэрээг дуусгавар болгох, цуцлах үндэслэл үл болно.

10.4 Гэрээний нөхцөлд талууд харилцан тохиролцсоноор нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тохиолдолд орох нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулна. Нэмэлт, өөрчлөлт нь энэхүү Гэрээний салшгүй хэсэг болно.

ТАЛУУД

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Санхүү, аж ахуйн хэлтсийн
дарга X.Цогтбаатар

Олон нийт, хэвлэл мэдээллийн асуудал
хариуцсан ажилтан В.Энхтувшин

Хаяг: Улаанбаатар, Монгол Улс 17120

Утас: 77002099, 77002039

АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“Хулан шоу энтертейнмент” ХХК-ийн
менежер УЛААНБААТАР ШОУ
INTERTAIMENT Б.Золбадрах

Утас: 88018034, 99188757

И-мэйл: Bronx8707@gmail.com